



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
НАРИЙНТЭЭЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 01 сарын 02 өдөр

Дугаар А/01

Нарийнтээл сум

Хөрөнгө орлогод авах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.5, Захиргааны ерөнхий хуулийн 43, 46 дугаар зүйл, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2024 онд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн 407,918,140 /дөрвөн зуун долоон сая есөн зуун арван найман мянга нэг зуун дөч/ төгрөг, Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 67,473,294 /жаран долоон сая дөрвөн зуун далан гурван мянга хоёр зуун ерэн дөрөв/ төгрөг нийт 475,391,434 /дөрвөн зуун далан гурван сая гурван зуун ерэн нэгэн мянга дөрвөн зуун гучин дөрөв/ төгрөгийн хөрөнгийг тухайн байгууллагын хөрөнгөд бүртгэн авсугай.

2.Хөрөнгө орлогод авах байгууллагын нэр, хөрөнгийн хэмжээг хавсралтаар баталсугай.

3.Орон нутгийн хөгжлийн сан болон бусад хөрөнгөөр бий болсон 475,391,434 төгрөгийн хөрөнгийг тухайн хөрөнгийг эзэмшиж байгаа байгууллагын хөрөнгөнд бүртгэх ажилд хяналт тавьж ажиллахыг төсвийн ерөнхий нягтлан бодогч (Г.Наранхүү)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



С.ЦОГТБААТАР

Нарийнтээл сумын Засаг даргын 2025
оны 01 дүгээр сарын 02 ны өдрийн 1101
дүгээр захирамжийн хавсралт

ХӨРӨНГӨ ОРЛОГОД АВАХ БАЙГУУЛЛАГУУДЫН НЭРС

(мянган төгрөгөөр)

№	Төсөл, арга хэмжээний нэр	Эх үүсвэр	Хөрөнгө орлогод авах дүн	Хөрөнгө орлогод авах байгууллага
1	Өндөр хөмөг, цагаан овоо багийн төвийг засварлах өргөтгөх	Орон нутгийн хөгжлийн сан	31,988.50	ЗДТГ
2	Ахмадын өрөөний засвар	Орон нутгийн хөгжлийн сан	72,653.70	ЗДТГ
3	Залуучуудын фитнесс төв	Орон нутгийн хөгжлийн сан	48,970.00	ЗДТГ
4	Баяр наадмын зардал /Хурдан морь хэмжигч/	Орон нутгийн хөгжлийн сан	500.00	ЗДТГ
5	Халуун усны засвар	Орон нутгийн хөгжлийн сан	10,000.00	ЗДТГ
6	Эко жорлон хийх ажил	Орон нутгийн хөгжлийн сан	7,980.00	ЗДТГ
7	Сумын төвийн иргэний танхимын тохижилт	Орон нутгийн хөгжлийн сан	35,150.24	ЗДТГ
8	Багийн төвийн худагт цэвэршүүлэг тавих	Орон нутгийн хөгжлийн сан	19,990.00	ЗДТГ
9	Спорт заал, ЕБС-ийг камержуулах	Орон нутгийн хөгжлийн сан	14,595.00	Нарийнтээл ЕБС
10	Сумын төвийн хичээлийн байрны сантехникийг засварлах	Орон нутгийн хөгжлийн сан	79,462.10	Нарийнтээл ЕБС
11	Цэцэрлэгийн гадна талбайн тохижилт	Орон нутгийн хөгжлийн сан	19,800.00	Нарийнтээл СӨББ
12	Баянтээг багийн хүүхдийн тоглоомын талбайг тохижуулах	Орон нутгийн хөгжлийн сан	19,980.00	Баянтээг СӨББ
13	Соёлын төвийн номын сангийн тохижилт, түүх соёлыг хамгаалах, хаягжуулах	Орон нутгийн хөгжлийн сан	30,000.00	Соёлын төв
14	Соёлын төвд хөгжим техник хэрэгслийн хөрөнгө оруулалт хийх	Орон нутгийн хөгжлийн сан	16,848.60	Соёлын төв
15	Нарийнтээл сумын Соёлын төвийн засвар	Аймгийн төсвийн хөрөнгө оруулалт	67,473.29	Соёлын төв
	ДҮН		475,391.43	



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
НАРИЙНТЭЭЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 01 сарын 02 өдөр

Дугаар A/02

Нарийнтээл сум

Г Сарчилсан төлөвлөгөө батлах тухай Г

Төсвийн тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1.6 дахь заалт, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн "Сумын 2024 оны төсөв батлах тухай" хуралдааны 03/05 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын орон нутгийн орлогыг 1 дүгээр хавсралтаар, Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төсвийн сарчилсан хуваарийг 2 дүгээр хавсралтаар, Засаг даргын Тамгын газрын төсвийн сарчилсан хуваарийг 3 дугаар хавсралтаар, багуудын төсвийн сарчилсан хуваарийг 4 дугаар хавсралтаар, Ерөнхий боловсролын сургууль, Сургуулийн өмнөх боловсролын байгууллага, Эрүүл мэндийн төв, Баянтээг багийн бага сургууль, Сургуулийн өмнөх боловсролын байгууллага, Хүн эмнэлэг, Соёлын төв зэрэг байгууллагуудын тогтмол зардал болон гэрээт ажилчдын цалинг 5 дугаар хавсралтаар, Хоршоо хөгжүүлэх сангийн зарцуулалтын хуваарийг 6 дугаар хавсралтаар, Эрсдэлээс хамгаалах сангийн сарчилсан хуваарийг 7 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Дээрх байгууллагуудын төсвийг батлагдсан төсөвт багтаан сарчилсан хуваарийн дагуу зарцуулж байгаад хяналт тавьж ажиллахыг Төсвийн ерөнхий нягтлан бодогч (Г.Наранхүү)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



С.ЦОГТБААТАР



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
НАРИЙНТЭЭЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 01 сарын 03 өдөр

Дугаар А/03

Нарийнтээл сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4, Цэргийн албаны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.4, 34.1, Захиргааны ерөнхий хуулийн 43, 46 дугаар зүйл, аймгийн Засаг даргын 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн "Цэргийн бүртгэл явуулах тухай" А/01 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2025 оны цэргийн бүртгэлийг явуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Б.Ичинноров (Тамгын газрын дарга)

Гишүүдэд: Ч.Оюунзул (Архив, бичиг хэргийн ажилтан)

Н.Мягмаржав (Газрын даамал)

О.Цэрэннадмид (1 дүгээр багийн Засаг дарга)

Б.Базарсад (2 дугаар багийн Засаг дарга)

О.Мягмар (3 дугаар багийн Засаг дарга)

Ц.Мөнх-Эрдэнэ (4 дүгээр багийн Засаг дарга)

Т.Батдулам (Насан туршийн суралцахуйн нэгжийн багш)

2.Цэргийн тоо бүртгэлийг Шарга, Өндөрхөмөг, Цагаан-Овоо багууд 2025 оны 01 дүгээр сарын 06-ны өдрөөс 18, Баянтээг багт 2025 оны 01 дүгээр сарын 06-ны өдрөөс 16-ныг хүртэлх хугацаанд явуулсугай.

3.Багийн Засаг дарга нарт ээлжит цэргийн тоо бүртгэлийн бэлтгэлийг хангаж, 18-65 насны I,II дүгээр зэргийн бэлтгэл үүрэгтэн эрчүүд, тусгай мэргэжлийн эмэгтэйчүүдийн судалгааг бэлэн болгож бүрэн хамруулахыг үүрэг болгосугай.

4.Цэргийн тоо бүртгэлийг чанартай, үнэн зөв явуулж, дүн мэдээг хугацаанд нь аймгийн Цэргийн штабт хүргэхийг ажлын хэсэг (Б.Ичинноров)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



С.ЦОГТБААТАР



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
НАРИЙНТЭЭЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 01 сарын 07 өдөр

Дугаар А/04

Нарийнтээл сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.3 дахь заалт, Захиргааны ерөнхий хуулийн 43, 46 дугаар зүйл, Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн "Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай" 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1."Сумын хэмжээний хот тохижилт үйлчилгээний хүрээнд сумын төвд хогийн менежментийг хэрэгжүүлэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Б.Лхамсүрэн (Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн)

Гишүүд: Г.Наранбаатар (Бэлчээр, газар тариалан хариуцсан ажилтан)

Д.Отгонтуяа (ТатварынУлсын байцаагч)

Э.Мөнхбат (Засаг даргын Тамгын газрын нярав)

Нарийн бичгийн дарга: Н.Нямсүрэн (Нийгмийн даатгалын байцаагч)

2.Бараа ажил үйлчилгээ худалдан авахдаа худалдан авах ажиллагааны журмыг мөрдөн ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Б.Лхамсүрэн)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



С.ЦОГТБААТАР



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
НАРИЙНТЭЭЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 01 сарын 08 өдөр

Дугаар А/05

Нарийнтээл сум

Тусгай зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43, 46 дугаар зүйл, Зөвшөөрлийг тухай хуулийн 5.3 дугаар зүйлийн 5.3.1, Тамхины хяналтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, 7.9 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тамхи худалдаалах, түүгээр үйлчлэх аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тавигдах шаардлагыг хангасан "Таац-2" хүнсний дэлгүүрт 2 жилийн хугацаатай тусгай зөвшөөрөл олгосугай.

2.Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл бүхий худалдааны газруудад хяналт тавьж ажиллахыг Хууль, эрх зүй хариуцсан мэргэжилтэн (С.Баасандулам), Хэсгийн төлөөлөгч, цагдаагийн ахлах дэслэгч (У.Мягмарнасан) нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



С.ЦОГТБААТАР



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
НАРИЙНТЭЭЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 01 сарын 21 өдөр

Дугаар А/06

Нарийнтээл сум

┌ Ажлын хэсэг байгуулах тухай ┐

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.3 дахь заалт, Захиргааны ерөнхий хуулийн 43, 46 дугаар зүйл, Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн "Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай" 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1."Сумын хэмжээний хот тохижилт үйлчилгээний хүрээнд Баянтээг багт хогийн менежментийг хэрэгжүүлэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Д.Бямбадолгор (Мал эмнэлгийн тасгийн дарга)

Гишүүд: Г.Наранбаатар (Бэлчээр газар тариалан хариуцсан мэргэжилтэн)

Т.Батдулам (Насан туршийн суралцахуйн нэгжийн багш)

А.Лхагвадолгор (Улсын бүртгэгч)

Нарийн бичгийн дарга: Н.Мягмаржав (Газрын даамал)

2.Бараа ажил үйлчилгээ худалдан авахдаа худалдан авах ажиллагааны журмыг мөрдөн ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Д.Бямбадолгор)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



С.ЦОГТБАААТАР



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
НАРИЙНТЭЭЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 01 сарын 25 өдөр

Дугаар А/07

Нарийнтээл сум

Тендерийн гүйцэтгэгчийг сонгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, 30.2, 48 дугаар зүйлийн 48.2.6, Захиргааны ерөнхий хуулийн 43, 46 дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Ажлын хэсгийн 2024 оны 12 дугаар сарын 24-ны өдрийн 01 дүгээр зөвлөмжийн дагуу орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжих "Мал эмнэлгийн машины завсар"-ын тендерийг 5,670,000 (таван сая зургаан зуун далан мянган) төгрөгөөр "А.Төмөрбаатар"-аар гүйцэтгүүлэхийг зөвшөөрсүгэй.

2.Хяналт тавьж гэрээ байгуулж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Б.Ичинноров)-д даалгасугай.

3.Гэрээнд заасан хуваарь, гүйцэтгэлийн дагуу санхүүжилт олгохыг төсвийн ерөнхий нягтлан бодогч (Г.Наранхүү)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



С. ЦОГТБААТАР



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
НАРИЙНТЭЭЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 01 сарын 27 өдөр

Дугаар А/08

Нарийнтээл сум

Тендерийн гүйцэтгэгчийг сонгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дүгээр зүйлийн 30.1, 30.2, 48 дүгээр зүйлийн 48.2.6, Захиргааны ерөнхий хуулийн 43, 46 дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Ажлын хэсгийн 2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 01 дүгээр зөвлөмжийн дагуу орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжих Сумын төвийн хогийн менежментийн ажлыг хэрэгжүүлэх тендерийг 19,008,000 (арван есөн сая найман мянган) төгрөгөөр “Эвийн хүч” бүлгээр гүйцэтгүүлэхийг зөвшөөрсүгэй.

2.Хяналт тавьж гэрээ байгуулж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Б.Ичинноров)-д даалгасугай.

3.Гэрээнд заасан хуваарь, гүйцэтгэлийн дагуу санхүүжилт олгохыг төсвийн ерөнхий нягтлан бодогч (Г.Наранхүү)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



С.ЦОГТБААТАР



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
НАРИЙНТЭЭЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 01 сарын 27 өдөр

Дугаар А/09

Нарийнтээл сум

Тендерийн гүйцэтгэгчийг сонгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дүгээр зүйлийн 30.1, 30.2, 48 дүгээр зүйлийн 48.2.6, Захиргааны ерөнхий хуулийн 43, 46 дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Ажлын хэсгийн 2025 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 01 дүгээр зөвлөмжийн дагуу орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжих Баянтээг багт хогийн менежментийн ажлыг хэрэгжүүлэх тендерийг 15,840,000 (арван таван сая найман зуун дөчин мянган) төгрөгөөр "Хамтын хүч" нөхөрлөлөөр гүйцэтгүүлэхийг зөвшөөрсүгэй.

2.Хяналт тавьж гэрээ байгуулж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Б.Ичинноров)-д даалгасугай.

3.Гэрээнд заасан хуваарь, гүйцэтгэлийн дагуу санхүүжилт олгохыг төсвийн ерөнхий нягтлан бодогч (Г.Наранхүү)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



С.ЦОГТБААТАР

**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН НАРИЙНТЭЭЛ СУМЫН БАРАА, АЖИЛ,
ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГҮЙЦЭТГЭГЧИЙГ
СОНГОН ШАЛГАРУУЛАХ АЖЛЫН ХЭСЭГ**

2025.01.27

Дугаар 01

"Цагаан-Овоо"

ЗАСАГ ДАРГА С.ЦОГТБААТАР ТАНАА

Үнэлгээний дүгнэлт, зөвлөмж
хүргүүлэх тухай.

Ажлын хэсгийн 2025 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн хурлаар Баянтээг багт хогийн менежментийг хэрэгжүүлэх ажлын тендерийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах асуудлыг хэлэлцлээ. Уг тендерийг "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль"-ийн 33 дугаар зүйлийн дагуу харьцуулалтын аргаар үнийн саналыг 2 аж ахуй нэгжид хүргүүлж 2025 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 10 цаг хүртэл хүлээн авч, 2025 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 10 цаг 50 минутанд үнийн саналыг нээж сонгон шалгарлуулалтыг хийсэн.

Сонгон шалгаруулалтыг "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль"-ийн 26, 27, 28 дугаар зүйлүүдийн дагуу хянан үзэж хэлэлцсэн байна.

Малын эрүүл мэндийн үйлчилгээнд зарцуулах тендерийн нийлүүлэгчийг сонгон шалгаруулалтанд "Хамтын хүч" нөхөрлөл нь 15.840.000 төгрөгийн үнийн санал ирүүлснээр "Хамгийн сайн" үнэлэгдсэн тендер гэж гишүүдийн 100 хувийн саналаар дэмжсэн болно.

Үнийн саналд оролцсон "Хамтын хүч" нөхөрлөлийн үнийн саналыг "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль"-ийн 14-16 дугаар зүйл, тендерийн баримт бичигт заагдсан үндсэн нөхцөл шаардлагын дагуу хянан үзээд шаардлага хангасан гэж үнэлэгдсэн дээрх нөхөрлөлийн үнийн саналыг мөн хуулийн 28.3 дахь заалтыг үндэслэн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж дараах зөвлөмж, дүгнэлтийг танд хүргүүлж байна.

2025 оны орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх Баянтээг багт хогийн менежментийг хэрэгжүүлэх ажлыг сонгон шалгаруулах үнийн саналд "Хамтын хүч" нөхөрлөлийг 15.840.000 төгрөгийн саналыг нийлүүлэгчээр шалгарууллаа.

АЖЛЫН ХЭСГИЙН АХЛАГЧ
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



Д.БЯМБАДОЛГОР
Н.МЯГМАРЖАВ



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
НАРИЙНТЭЭЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 01 сарын 28 өдөр

Дугаар А/140

Нарийнтээл сум

Газар эзэмших эрхийн гэрчилгээний
хугацааг сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 43, 46 дугаар зүйл, Газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, 37 дугаар зүйлийн 37.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Өндөрхөмөг 3-р багийн Ар өлтийн өвсний мухар гэх газарт байрлах иргэн Энхтуяа овогтой Одбаатар (ИЙ90010914)-ийн эзэмшлийн 0.07га /700.0 м²/ өвөлжөөний доорхи газрын газар эзэмших эрхийг 40 жилийн хугацаагаар сунгасугай.

2.Газар эзэмшигчдэд газар эзэмших эрхийн гэрчилгээ олгож, гэрээ байгуулж, улсын бүртгэлд бүртгэхийг газрын даамал (Н.Мягмаржав)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



С.ЦОГТБААТАР



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
НАРИЙНТЭЭЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 01 сарын 31 өдөр

Дугаар А/11

Нарийнтээл сум

┌ Тендерийн гүйцэтгэгчийг сонгох тухай ┐

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, 30.2, 48 дугаар зүйлийн 48.2.6, Захиргааны ерөнхий хуулийн 43, 46 дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үнэлгээний хорооны 2025 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 03 дугаар зөвлөмжийн дагуу орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжих "Ерөнхий боловсролын сургуулийн гал тогооны тоног төхөөрөмж худалдан авах" ӨВАНТСЗДТГ/20240202004 дугаартай барааны багц-2 тендерийг 9,830,000 (есөн сая найман зуун гучин мянган) төгрөгөөр "ЧИГЛЭЛ ХХК"-иар гүйцэтгүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Хяналт тавьж гэрээ байгуулж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Б.Ичинноров)-д даалгасугай.

3. Гэрээнд заасан хуваарь, гүйцэтгэлийн дагуу санхүүжилт олгохыг төсвийн ерөнхий нягтлан бодогч (Г.Наранхүү)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



С.ЦОГТБААТАР

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН НАРИЙНТЭЭЛ СУМЫН ҮНЭЛГЭЭНИЙ ХОРОО

2025.01.21

Дугаар 03

"Цагаан-овоо"

ЗАСАГ ДАРГА С.ЦОГТБААТАР ТАНАА

Үнэлгээний дүгнэлт, зөвлөмж хүргүүлэх

тухай


"Ерөнхий боловсролын сургуулийн гал тогооны тоног төхөөрөмж худалдан авах" ӨВАНТСЗДТГ/20240202004/ багц-2 ажлыг цахимаар зарлаж 2025 оны 01 дугаар сарын 17-ны өдрийн 10 цаг 00 минут хүртэл тендерийг хүлээн авч 2025 оны 01 дугаар сарын 17-ны өдрийн 10 цаг 50 минутанд нээсэн.


Тендерийг нээхэд үнэлгээний хорооны гишүүд 2025 оны 01 дугаар сарын 21-ны өдөр 100% ирцтэй хуралдаж "Ерөнхий боловсролын сургуулийн гал тогооны тоног төхөөрөмж худалдан авах" ӨВАНТСЗДТГ /20240202004/ барааны багц-2 гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах асуудлыг хэлэлцсэн.

"Чиглэл" ХХК, "Галт алтан арслан" ХХК, "Тэдди эдди" ХХК-ын ирүүлсэн тендерийн бичиг баримтыг "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан тухай хууль"-ийн 26,27 дугаар зүйлд заасны дагуу хянан үзэж хэлэлцсэн.

Иймд дээрх ажлыг гүйцэтгэхээр үнийн санал ирүүлсэн "Чиглэл" ХХК-ний үнийн саналыг "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль"-ийн 27 дугаар зүйлийн 27.5-р зүйлд заасны дагуу хамгийн сайн тендер гэж үнэлгээний хорооны гишүүд үзэж байна.

"Ерөнхий боловсролын сургуулийн гал тогооны тоног төхөөрөмж худалдан авах" ӨВАНТСЗДТГ/20240202004/ дугаартай багц-2 барааны гүйцэтгэгчийг шалгаруулах тендерт "Чиглэл"-ХХКомпани 9,980,000 төгрөгний үнийн санал ирүүлсэн ба мөн хуулийн 8 дугаар зүйлийн 8.5 т заасны дагуу дотоодын бараа ашиглах санал болгосон бол давуу эрх тооцно гэсний дагуу дотоодын барааны хэсгийн үнийн 10 хувийг тооцож 9,830,000 төгрөгний үнийн саналыг үнэлгээний хорооны гишүүдийн 100 хувийн саналаар дэмжиж зөвлөмжийг хүргүүлж байна.

ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ ДАРГА  С.БААСАНДУЛАМ

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА  А. БААСАНДОЛГОР